



## ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО, ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН ТОГТООЛ

2023 оны 08 сарын 28 өдөр

Дугаар 412

Улаанбаатар хот

### Үндсэн хөрөнгө данснаас хасах, бүртгэх зөвшөөрөл олгох тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 8, 31 дүгээр зүйлийн 1, 3 дахь заалт, Засгийн газрын 2008 оны 148 дугаар тогтоолын 1 дэх заалт, Засгийн газрын 2023 оны 01 дүгээр сарын 18-ний өдрийн 4 дүгээр тэмдэглэл, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны 271 дүгээр тогтоолоор баталсан “Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам”-ын 6.2.1, 6.4.3, 6.4.4 дэх заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1.Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар (Архангай аймгийн Мэргэжлийн хяналтын газар)-ын үндсэн хөрөнгөнд бүртгэлтэй 52,000,000.00 (тавин хоёр сая) төгрөгийн балансын үнэ 41,333,333.33 (дөчин нэгэн сая гурван зуун гучин гурван мянга гурван зуун гучин гурван төгрөг гучин гурван мөнгө) төгрөгийн хуримтлагдсан элэгдэл бүхий ашиглалтын хугацаа дуусч дахин үнэлгээ хийгдсэн Тоёото Ландкрузер-105 маркийн 7000 APX улсын дугаартай автомашиныг төрийн өмчийн данс бүртгэлээс хасч, Архангай аймгийн өмчид (Булган сумын ЗДТГ-т) бүртгэхийг зөвшөөрсүгэй.

2.Төрийн өмчийн бүртгэл, ашиглалтын хэлтэс (Д.Нарангэрэл), Архангай аймгийн Орон нутгийн өмчийн газрын дарга Х.Ганхуяг, Архангай аймгийн Булган сумын Засаг даргын Тамгын газрын дарга Н.Бат-Эрдэнэ нарт дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай:

2.1.Байгууллагын өмч хамгаалах Байнгын зөвлөлийн хяналт дор хавсралтад заасан автомашиныг данснаас хасах, хүлээлгэн өгөх ажлыг холбогдох хууль тогтоомжийн дагуу зохион байгуулах;

2.2.Хавсралтад заасан хөрөнгийг эзэмшүүлэх, ашиглалтын хугацаа, үнийг шинэчлэн тогтоож, засаж сэлбэн ашиглах, данс бүртгэлд тусгах ажлыг зохион байгуулах;

2.3.Хөрөнгийн хөдлөлийг зохих хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусган, “Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх систем”-д бүртгэх;

2.4.Автомашиныг автотээврийн улсын бүртгэл, татварын бүртгэлээс шилжүүлэн Арга хэмжээний биелэлтийг 2023 оны 3 дугаар улиралд багтаан ирүүлэх.

3.Энэ тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэл, ашиглалтын хэлтэс (Д.Нарангэрэл)-т үүрэг болгосугай.

ДАРГА



Б.ЦЭНГЭЛ

ТӨРИЙН ӨМЧИЙН БҮРТГЭЛ,  
АШИГЛАЛТЫН ХЭЛТСИЙН ДАРГА

A handwritten signature in black ink, appearing to read 'Д.Нарангэрэл'.

Д.НАРАНГЭРЭЛ